



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 80

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгөд үнэлгээ тогтоож,  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 76,152,520 /далан зургаан сая нэг зуун тавин хоёр мянга таван зуун хорин/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй 2 ширхэг дотуур байрын барилгыг газаргүйгээр, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоон, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн), Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургууль (Г.Мягмарсүрэн) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх.

2.2 Үл хөдлөх хөрөнгийг дуудлагаар худалдсаны дараа газрыг чөлөөлүүлж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны  
өдрийн 80 дугаар тогтоолын хавсралт

Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн худалдах барилгын мэдээлэл

Д/Д	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалт ад орсон он	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Хэмжих нэгж	Биет хэмжээ						
1	Дотуур байр "А"	Байр	м2	430.3	1978	44	38,076,260	38,076,260	0	19,000,000 /арван есөн сая/ төгрөг
2	Дотуур байр "Б"	Байр	м2	430.3	1978	44	38,076,260	38,076,260	0	15,300,000 /арван таван сая гурван зуун мянга/ төгрөг
Дүн							76,152,520 /далан зургаан сая нэг зуун тавин хоёр мянга таван зуун төгрөг			